

Нэмэгдэл хөлс: ЗГ-ын 2018 оны 382-р тогтоолын 2-р хавсралт

Нэмэгдэл хөлс гэдэгт төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд илүү цагийн хөлсийг ойлгоно. Энэ нь Төрийн албаны тухай хуульд зааснаар 2020 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн хэрэгжинэ.

Илүү цаг гэж юу вэ?

Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу төрийн байгууллагын дотоод журмаар тогтоосон өдрийн ажлын цагийг ажил олгогчийн санаачлагаар хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажиллуулсанд, орон нутгийн цагаар 22 цагаас 06 цаг хүртэлх хугацаанд ажиллуулахыг шөнийн цагаар ажиллуулсанд, нийтээр амрах баярын өдрүүдэд ажиллуулахыг нийтээр амрах баярын өдөр ажиллуулсанд, Бямба, Ням гарагт ажиллуулахыг долоо хоног бүрийн амралтын өдөр ажиллуулсанд тус тус тооцож, нөхөн амруулагүй тохиолдолд нэмэгдэл хөлс олгоно

Илүү цагийн хөлсийг тооцох нь

Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан төрийн албан хаагчийг нөхөн амруулаагүй бол илүү цагийн хөлсийг тодорхойлохдоо сарын цалин хөлсний хэмжээг тухайн сарын ажиллавал зохих цагт хувааж, нэг цагт ногдох цалин хөлсийг тооцож гаргана. Нэг цагийн цалин хөлсийг илүү ажилласан цагаар үржүүлж гарсан цагийг 1.5 (1.5 ба түүнээс дээш байхыг хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээнд тусгаж зохицуулна) дахин нэмэгдүүлж, илүү цагийн хөлсний хэмжээг тодорхойлно.

Нийтээр амрах баярын өдөр ажилласан төрийн албан хаагчийг нөхөн амруулаагүй бол дээрх зарчмын дагуу нэг цагт ногдох цалин хөлсийг нийтээр амрах баярын өдөр ажилласан цагаар үржүүлж, түүнийг 2.0 дахин нэмэгдүүлэх замаар нэмэгдэл хөлсийг тодорхойлно.

Шөнийн цагаар ажилласан төрийн албан хаагчийг нөхөн амруулаагүй бол нэмэгдүүлсэн цалин хөлс олгох зохицуулалтыг хамтын ба хөдөлмөрийн гэрээнд тусгаж, дээрх зарчмын дагуу нэмэгдэл хөлсийг тодорхойлно.

Жич: Илүү цагийн хөлс тооцох цаг нь тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй.

Албан тушаалын онцгой нөхцөлийн нэмэгдэл

⇒ Улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар тогтоосугай. / ***УИХ-ийн 2007 оны 73 дугаар тогтоол/***

⇒ Онцгой байдлын байгууллагын алба хаагчид алба хаах хугацаанд нь албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг сарын үндсэн цалингийн 20 хувиар тооцож, сар бүр олгоно. / ***Засгийн газрын 2018 оны 380-р тогтоол/***

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА



**ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН
ЦАЛИН ХӨЛС**

УТАС: 70324171, 70322625

ФАКС: 70324171

ЦАХИМ ХУУДАС:
www.sankhuuhyanalt.ov.gov.mn

**АРВАЙХЭЭР ХОТ
2021 ОН**

Төрийн жинхэнэ албан хаагч гэж хэн бэ?

Төрийн албаны тухай хуульд зааснаар төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалыг хашиж байгаа хүнийг төрийн жинхэнэ албан хаагч гэнэ.

Төрийн захиргааны албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн

Албан тушаалын цалин + төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл + цолны нэмэгдэл + зэрэг дэвийн нэмэгдэл + докторын зэргийн нэмэгдэл + нэмэгдэл хөлс = 6 хэсэг

Төрийн тусгай албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн

Албан тушаалын цалин + албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдэл + төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл + цолны нэмэгдэл + зэрэг дэвийн нэмэгдэл + докторын нэмэгдэл + мэргэшлийн зэргийн нэмэгдэл + хуульд заасан бусад нэмэгдэл = 8 хэсэг

Тайлбар: Цол, зэрэг дэвийн нэмэгдлийг давхардуулан олгохгүй.

Албан тушаалын цалинг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Засгийн газрын тогтоолоор тогтоосон цалингийн сүлжээ, албан тушаалын ангилал зэрэглэл, ажилтын ажлын үр дүн зэргийг үндэслэн байгууллагын удирдлага тогтооно.

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл. ЗГ-ын 2018 оны 382-р тогтоолын 1-р хавсралт

Төрийн алба хаасан хугацаа (жилээр)	Албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох хувь
6-10 жилд	5
11-15 жилд	10
16-20 жилд	15
21-25 жилд	20
26 ба түүнээс дээш	25

Тайлбар: Энэ журмын 2-т заасан төрийн алба хаасан хугацааны “жилд” гэснийг “тухайн жил дуустал” гэж, “6-10 жилд” гэснийг “6 дахь жилийн эхнээс олгоно” гэж тус тус ойлгоно.

Докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл. ЗГ-ын 2018 оны 382-р тогтоолын 3-р хавсралт

Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль тогтоомжоор заасан байгууллагад сургалт, эрдэм шинжилгээ, туршилтын ажил эрхэлдэг, эрдэм шинжилгээний байгууллагад болон судалгаа шинжилгээ, туршилтын үндсэн үйлдвэрлэл дээр ажилладаг албан тушаалтанд.

Эрдмийн зэрэг, цол	Албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох хувь
Шинжлэх ухааны доктор зэрэг	20
Профессор цол	10
Боловсролын доктор зэрэг	15
Дэд профессор цол	5

Бусад байгууллагад ажиллаж байгаа бол

Эрдмийн зэрэг, цол	Албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох хувь
Шинжлэх ухааны доктор зэрэг	15
Боловсролын доктор зэрэг	10

Зэрэг дэвийн нэмэгдэл. УИХ-ын 2019 оны 21 дүгээр тогтоол.

Албан тушаалын ангилал	Зэрэг дэвийн нэмэгдэл /хувиар/			
	Тэргүүн зэрэг	Дэд зэрэг	Гутгаар зэрэг	Дөтгөр зэрэг
Тэргүүн түшмэл	48	46	44	42
Эрхэлсэн түшмэл	40	38	36	34
Ахлах түшмэл	32	30	28	26
Дэс түшмэл	24	22	20	18
Туслах түшмэл	16	14	12	10